



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 6/152

Улаанбаатар хот

Д.Батжаргалд сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.3, 26.8, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ын 2 дугаар зүйлийн 3, 4, 5 дахь заалт, Архивын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 6.1.14, 6.2.3, 13.1-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй Мэдээллийн технологийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Батжаргалд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.


2. Хариуцсан нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэр, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Д.Батжаргалд үүрэг болгосугай.

3. Дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд дараагийн шатны сахилгын арга хэмжээ авахыг Д.Батжаргалд сануулсугай.

4. Дээрх зөрчлийг гаргахгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

5. Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо энэхүү шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллагад гаргаж болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБААТАР



Tushaal
388110706